



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 8/52

Хэрлэн сум

Мөнгөн шагналаар шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3.1, 3.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалахын яамны сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гэрээний хэрэгжилтийг А (маш сайн) үнэлгээтэй дүгнүүлж, улсын тэргүүний цэргийн штабаар шалгарсан амжилтыг нь үнэлж, Цэргийн штабын дарга Намсрайн Хүрэлээг 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар шагнасугай.

2. Шагналын зардалд зарцуулах 1,452,000 (нэг сая дөрвөн зуун тавин хоёр мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн мөнгөн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР